

Хятад-Монголын ашигт малтмалын хамтын ажиллагааны геополитик, гео-эдийн засгийн ач холбогдлын тухай

Б.Хөгжилт *

Товч агуулга: Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хамгийн давуу тал нь ашигт малтмалын асар их нөөц юм. Монгол Улс уул уурхайн салбараа түшиглэн улсаа хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж буй бол Хятад улс эрдэс баялаг, эрчим хүчний эрэлт хэрэгцээгээр дэлхийн хамгийн том орон болоод байна. Одоогоор хотжилт, үйлдвэржилтийн дунд шатанд оршиж, ирээдүйн нэлээд урт хугацаанд энэхүү статусаа хэвээр хадгалахын зэрэгцээ эрчим хүчний аюулгүй байдлаа олон талтай болгох, “Гадаадад гарах” стратеги хэрэгжүүлж байна. Иймээс хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны гол салбар нь нэгэнт уул уурхай, дэд бүтэц, санхүүгийн хамтын ажиллагаа болсон бөгөөд “Гурвыг уялдуулан цогцоор ахиулах” зарчмын үе шатанд шилжээд байна. Сүүлийн үед хоёр улс тус тусдаа “Торгоны замын эдийн засгийн бүс” стратеги, “Талын зам” санаачлага дэвшүүлж хэрэгжүүлсэнээр, хоёр талын тус салбар дахь хамтын ажиллагаанд нэн их боломж, хамтрах тавцаныг бий болгов. Ийнхүү Хятад-Монголын ашигт малтмалын хамтын ажиллагааны геополитик, гео-эдийн засгийн ач холбогдол дараахь 4 чиглэлээр тодорхойлогдож байна. Үүнд: 1. Хятад-Монголын түшиглэсэн маягийн геостратегийн хамтын нийгэмлэгийг бий болгоход таатай. 2. “Хойд зүгийн” хамгийн ойр дөхөм нөөц баялгийн нийлүүлэлтийн түнштэй болно. 3. Тогтвортой, дөхөм дамжин өнгөрөх тээвэр, логистик худалдааны коридарыг бий болгоно. 4. Бүс нутгийн интеграцийн механизм бүрдэх үйл явцыг ахиулна.

* Б.Хөгжилт – Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын сургуулийн Хөрш орон судлах хүрээлэнгийн дэд профессор

Түлхүүр үг: Хятад-Монгол, уул уурхайн хамтын ажиллагаа, гео, ач холбогдол

Abstract: In Mongolia, the rich mineral resources is the biggest advantage of its economic development. Mongolia based on this, implementing the policy of developing the country by relying on mining. China has the greatest needs of energy and resources in the world, and, China is currently in the middle stage of urbanization and industrialization. In the future for a long period of time will still maintain a demand for energy and resources. Based on this, it implements the diversification of the national energy security and "going out" strategy. Therefore, it have been confirmed as early as in 2003, when President Hu Jintao visit to Mongolia, key areas of bilateral economic and trade cooperation are mineral resources development and infrastructure construction. With the further promotion of the bilateral relations between China and Mongolia, key areas of bilateral economic and trade cooperation has been extended to the mineral resources development, infrastructure construction and financial cooperation, Trinity, co-ordinate to promotion stage in principle. Recently, the two countries were put forward "the Silk Road Economic Zone national strategy," road of the grassland "proposal, to build a broader platform for cooperation in the bilateral fields. The significance of Sino-Mongolian cooperation in the geopolitical and economic field : 1) to construct Sino-Mongolia mutual dependent geo- strategic community. 2) to build the nearest resource supply "to the north". 3) build a stable and convenient transit transport and logistics trade channel. 4) to promote regional integration processes.

Keywords: Sino-Mongolia, mineral cooperation, geopolitics, significance

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хамгийн давуу тал нь ашигт малтмалын асар их нөөц бөгөөд Монгол Улс үүндээ суурилан уул уурхайн салбараа түшиглэн улсаа хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Хятад бол эрдэс баялаг, эрчим хүчний эрэлт хэрэгцээгээр дэлхийн хамгийн том орон болсон бөгөөд одоохондоо хотжилт, үйлдвэржилтийн дунд шатанд байж, ирээдүйн нэлээд урт хугацаанд энэхүү статусаа хэвээр хадгалах болно. Мөн түүнчлэн эрчим хүчний аюулгүй байдлаа олон талаас нь хангах, "Гадаадад гарах" стратеги хэрэгжүүлж байна. Иймээс бүр 2003 онд Хятад улсын дарга Ху Зиньтао Монголд айлчлах үеэр хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны гол салбарыг ашигт малтмал, дэд бүтцийн бүтээн байгуулалт гэж тодорхойлсон байдаг. Хоёр талын харилцаа цаашид сайжрахын хэрээр эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны

гол салбар нэгэнт ашигт малтмал, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагаа болсон бөгөөд цаашдаа “Гурвыг уялдуулан цогцоор ахиулах” зарчмын шинэ үе шатанд дэвшин орж байна. Хоёр улсын хувьд ийнхүү нийтлэг ашиг сонирхол оршин буй бөгөөд ялангуяа хоёр тал тус тусдаа “Торгоны замын эдийн засгийн бүс” стратеги, “Талын зам” санаачлага дэвшүүлж хэрэгжүүлсэнээр хоёр талын уул уурхайн салбар дахь хамтын ажиллагаанд нэн их боломж, хамтрах тавцаныг бий болгож байна. Хятад-Монголын ашигт малтмалын хамтын ажиллагааны геополитик, гео-эдийн засгийн ач холбогдол нь дор дурдсан чиглэлүүдээр тодорхойлогдож байна. Үүнд:

1. Хятад-Монголын харилцан хамааралтай геостратегийн хамтын нийгэмлэгийг бий болгоход таатай болох нь.

Хоёр улс нь бие биетэйгээ хамгийн урт хилийн шугамтай орон болохоор геостратегийн нийтлэг ашиг сонирхол ихтэй байдаг. Геостратегийн ашиг сонирхлыг хангах бодитой арга зам нь өргөн хүрээтэй, олон түвшний, бүх талын хамтын ажиллагаа юм. Улмаар энэхүү түншлэл нь харилцан ашигтай, хамтдаа хожих эдийн засгийн хамтын ажиллагааг сууриа болгодог. Эдийн засгийн хамтын ажиллагаанд эзлэх хувийн жингээр хамгийн их, хамгийн тулгамдсан, хамгийн хүндрэлтэй нь мөнхүү ашигт малтмалын салбар дахь хамтын ажиллагаа байна. Тиймээс Хятад-Монголын ашигт малтмалын хамтын ажиллагааг зүй зохистой, олон талыг харгалзсан байдлаар хөгжүүлэх нь харилцан хамааралтай геостратегийг хэрэгжүүлэх нэг зорилт бөгөөд танайд манайх, манайд танайх байх, харилцан итгэлцсэн, сэжиг эргэлзээгүй, хэн нь ч хэнээсээ салж холдохгүй уур амьсгалыг үүсгэх, Хятад-Монголын харилцан түшсэн маягийн геостратегийн хамтын нийгэмлэгийг бий болгохын чухал алхам болно.

2. “Хойд зүгийн” нөөц баялгийн хамгийн ойр дөхөм түнш болох нь

Хятадын хэрэгжүүлж байгаа эрчим хүчний аюулгүй байдлын олон талт байдал, “гадаадад гарах” стратегийн сонголтод Австрали, Бразил, Энэтхэг, Орос, Персийн булангийн улсууд зэрэг нөөц баялгийн томоохон нийлүүлэгч улсаас гадна хөрш болон байгалийн баялаг ихтэй Африк, Латин Америкийн улсууд Хятадын эн тэргүүний сонголтод хамрагдана.

Монгол Улс нь ашигт малтмалаар баян, нөөц арвин, ашиглалтын зардал болон лицензийн төлбөр хямд, ашиглалтын хэтийн төлөв сайн. Түүнчлэн хоёр орны уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, худалдааны хамтын ажиллагааны хувьд жам ёсны нэлээд давуу нөхцөл боломжууд байдаг. Үүнд:

- 1) Хятад-Монголын улс төрийн харилцаа хамгийн өндөр түвшинд хүрч, эдийн засгийн хамтын ажиллагаа тодорхой хэмжээний хөрс суурьтай болсон байна. 1989 оноос хоёр орны харилцаа хэвийн болж, ялангуяа сүүлийн арваад жилийн хугацаанд өндөр түвшний айлчлал тогтмолжиж, 2011 онд стратегийн түншлэлийн харилцаанд хүрч, 2014 онд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд дэвшин оров. Хятад нь олон жилийн турш Монголын хамгийн том худалдааны түнш, хамгийн том хөрөнгө оруулагч болох байр суурийг хадгалж, эдийн засгийн хамтын ажиллагааны тодорхой хэмжээний хуримтлалтай болсон байна.
- 2) Газар зүйн хувьд ойр дөхөм. Монгол улс бол Хятадын Бээжин-Тяньзинь аж үйлдвэрийн бүс, Бохай Эдийн засгийн бүс, Зүүн хойдын аж үйлдвэрийн бүсээс хамгийн ойр орших нөөц баялаг ихтэй хөрш орон юм. Одоо хоёр орны хооронд нээлттэй хилийн боомт 16 бий, Монголын хил дэх зам тээвэр, боомтын байгууламж зэрэг дэд бүтцийн хатуу нөхцөл, хоёр талын хамтын ажиллагааны механизмын зөөлөн нөхцлийг шийдвэрлэвэл Хятадын Шаньси-Өвөрмонголын байгалийн баялаг ихтэй бүс нутагтай хамтдаа Хятадын эдийн засгийн тогтвортой хөгжлийн нөөц баялгийн нийлүүлэлтийн хүчирхэг бааз болж болно.
- 3) Хоёр орны уул уурхайн салбарын бодлогын нийцэл зохицол. Монгол улс нь уул уурхайн салбараа түшиглэн улсаа хөгжүүлэх стратеги хэрэгжүүлж буй. Монгол Улсын боловсруулсан эн тэргүүнд уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратеги нь хоёр үе шаттайгаар хэрэгжих бөгөөд нэгдүгээр үе шатанд уул уурхайн хөгжил, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортоор дэд бүтэц, холбогдох үйлдвэрлэлийг дайчлан хөгжүүлж, хоёрдугаар үе шатанд сольж олсон хөрөнгө, технологийн хуримтлалд түшиглэн, төрөлжсөн, зүй зохистой аж үйлдвэрийн бүтцийг

хөхиүлэн байгуулах юм. Хятадын нөөц баялгийн хэрэгцээ асар их, зах зээл хумигдсаар буй тул эрчим хүчний эх үүсвэрийг олон талт болгох, “гадаадад гарах” стратеги хэрэгжүүлж байна. Хоёр орон нэгэнт ашигт малтмалын хөгжил, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагааг хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны гол салбар гэж тодорхойлсон билээ.

- 4) Эдийн засгийн бие биеэ нөхөх байдал. Хоёр орон нь нөөц, хөрөнгө, технологи, менежментийн туршлага, маркетинг, ажиллах хүч, аж үйлдвэрийн орон зайн шилжилт зэрэг олон талаар бодит байдлаар бие биеэ нөхөх ихээхэн нөөц бололцоотой. Энэ бол хоёр орны хооронд дутагдаж буй бодит татах хүчин юм.
- 5) Өвөр Монголын зуучлалын болон гүүрийн үүрэг роль. Өвөр монголчууд монголчуудтай гарал үүсэл нэгтэйн хувьд хэл, соёлын талаар ижил буюу ижил төстэй байдаг. Энэ нь улс хоорондын харилцаанд хүмүүнлэгийн давуу тал болох бөгөөд бизнесийн харилцааг холбож ойртуулахад тус дөхөм үзүүлж байна.

3. Тогтвортой, дөхөм дамжин өнгөрөх тээвэр, логистик худалдааны коридорыг бий болгох нь

Монгол нь ашигт малтмалын нөөц ихтэйгээс гадна Хятадын “хойд зүгийн” стратеги, Евроазийн далай, хуурайн зам хосолсон тээвэрт эзлэх байр суурийн давуу талыг ч анзаарахгүй байж боломгүй. Үүний зэрэгцээ Монгол Улсын эх газрын, далайн гарцгүй байдал нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол саадын нэг болсон хэвээр байна. Иймд 2014 оны 8-р сард байгуулсан “Хятад-Монголын хамтарсан мэдэгдэл”-д дурдсан бодит агуулга, холбогдох заалтын дагуу хамгийн ойр, дөхөм дамжин өнгөрөх тээврийн коридор, далайн гарцыг нээж болно.

Хятадын “хойд зүгийн” стратегийн хувьд Оросын Сибирь, Алс Дорнод бол дэлхийн хэмжээний баялаг ихтэй бүс нутаг юм. Одоогийн байдлаар Хятад-Оросын эрчим хүчний хамтын ажиллагаа эрчимтэй хэрэгжиж байна. Харин Оросын Сибирээс Хятад руу экспортлох хамгийн ойр дамжин өнгөрөх шугамууд Монголоор дайран өнгөрөх боломжтой. Монголын нэгэнт тавигдсан төмөр зам Оростай хоёр

цэг, Хятадтай нэг цэгээр холбогдохоос гадна, баригдаж байгаа болон төлөвлөгдөж байгаа нь Оростой нэг цэг, Хятадтай гурван цэгээр холбогдох гэж байна.

Монголын санаачилсан “Талын зам” төсөл нь Хятад, Оросын хооронд орших газар зүйн давуу талдаа суурилан, төмөр зам, хурдны автозам, газрын тос болон байгалийн хийн дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамаар Хятад-Оросыг холбох зорилготой юм. Түүний тодорхой төслүүд гэвэл Хятад-Оросыг холбох 997 км урт хурдны зам, 1100 км урт эрчим хүчний шугам, Транс-Монголын төмөр замын өргөтгөл, байгалийн хий болон газрын тосны дамжуулах хоолойг барьж байгуулах ажлууд багтах ба урьдчилсан байдлаар нийт 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах ажээ¹.

2014 оны 9-р сарын 11-нд болсон Хятад, Монгол, Орос гурван улсын төрийн тэргүүний анхдугаар уулзалтын үеэр хүрсэн “Хятад, Монгол, Орос-ын эдийн засгийн коридор”-ыг хамтаар байгуулах тохиролцоо бол Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс, “ОХУ-ын Транс-Евразийн төмөр зам”, Монголын “Талын зам” санаачилгатай ихээхэн нийцэж холбогдох боломжтой юм². Зөвхөн эдийн засгийн үүднээс үзэхэд Хятад Оросыг холбосон тээвэр, эрчим хүчний шугам, хоолойнууд Монгол улсаар дамжин өнгөрөх нь одоо барьж буй болон төлөвлөж байгаа газрын тос, байгалийн хийн хоолойн зүүн, баруун шугамуудын аль алинаас бүр хэмнэлтэй юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2014 оны 11-р сарын 8-нд болсон АПЕК-ийн “дэд бүтцийн” түншлэлийн харилцаагаа бэхжүүлэх хуралд оролцох үеэр хэлэхдээ, Монгол улс далайн гарцгүй, гэхдээ Ази-Европыг холбосон хамгийн дөт гүүр мөн, одоо Ази-Европ, Хятад-Оросын хоорондын худалдаа эрчимтэй нэмэгдэж буй, хэрэв Монгол Улс өөрийн газар зүйн давуу талаа ашиглаваас Хятад-Оросын хоорондын худалдаа, тээвэрлэлтэд тус дөхөм үзүүлэх төдийгүй, Хятад, Оростой хамтран Евразийн тээврийн коридорыг Монголд байгуулах явдалд ихээхэн найдлага тавьж, бүс нутгийн логистикийн сүлжээнд

1 Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад руу зөөвөрлөдөг Монгол “Талын Зам”-аа яаралтай нэвтрүүлэхийг хүсч байна- Herald Tribune- албан ёсны вэб сайт-<http://ihl.cankaoxiaoxi.com/2014/1126/>

2 Си Зиньпин: Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулна. 人民网 Ардын вэб сайт [2014-09-12]

идэвхтэй оролцохоор хүчин чармайлт гаргаж байна. Монгол улс нэгэнт НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын хэрэгжүүлж байгаа Азийн автозамын сүлжээ, дамжин өнгөрөх төмөр замын сүлжээний төсөлд хамрагдаж, Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх Азийн хурдны автозамын сүлжээний АНЗ, АНЗ2, АН4 чиглэлүүдийг барьж дуусгахаар идэвхтэй ажиллаж байна. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын барилгын төслийг” нэгэнт эхлүүлж, 2016 онд ашиглалтад оруулхаар төлөвлөж байна. Тус онгоцны буудал ашиглалтад орсоноор Монгол нь Евразийн дамжин өнгөрөх тээврийн зангилаа болох юм гэжээ³.

Евразийн далай, хуурай замын хосолсон тээврийн хувьд, Тяньзинь боомт бол Монгол улсын хамгийн ойр далайн гарц юм. БНХАУ-ын эх газрын дөрвөн гүүрийн нэг болох Тяньзинь-Монгол-Евразийн нэгдсэн тээврийн коридор(бас Тяньзинь төсөл гэдэг) нь Тяньзиний Синьган боомтоос Бээжин, Датун, Эрээн хотыг дамжин Монголд нэвтрэн орж, Улаанбаатарыг дамжин умарш ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замаар Брест-д дахин ачилт хийж, баруун тийш Роттердам боомтод хүрдэг. Тус чиглэлийн тээвэр нь Кейп чиглэлтэй харьцуулбал зайг 1/2 гаруйгаар, Суэц чиглэлийнхээс зайг 1/3-ээр, хугацааг 35 хоногоор, тээврийн зардлыг 20-25% хэмнэдэг байна⁴.

Сүүлийн үед Тяньзинь-Монголын хамтын ажиллагаанд шинэ ахиц гарч, Тяньзинь болон Монгол улсын хооронд Тяньзиний Биньхай шинэ дүүргийн Дунзян дахь гаалийн баталгаат бүсэд 10 га газарт “Зинь-Мэн тээврийн логистикийн төсөл”-г 50 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан байна⁵.

Монгол улсын УИХ-аас 2014 оны 10-р сарын 24-нд Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн зарим арга хэмжээний тухай тогтоол баталж, Тавантолгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлд нарин царигийн төмөр зам тавихаар болов. Үүнд Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын газар шорооны ажил нэгэнт

3 Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад руу зөөвөрлөдөг Монгол "Талын Зам"-аа яаралтай нэвтрүүлэхийг хүсч байна-Herald Tribune- албан ёсны вэб сайт-<http://ihl.cankaoxiaoxi.com/2014/1126/>

4 Олон улсын мултимодаль тээврийн болон хуурай замын тээвэр _ Байду номын сан, <http://wenku.baidu.com/>

5 Монголын төмөр зам, <http://www.mtz.mn>

дуусах шатандаа орж буй. Өөр нэг нөөц баялгийн коридор болох Хөөт-Бичигтийн төмөр зам нь Зиньжоу далайн боомтын ашиглах асуудал нэгэнт шийдэгдсэнээс удахгүй эхлэх төлөвтэй байна. Төлөвлөгдөж байгаа Чойбалсан (эсвэл Хөөт)-аас Зиньжоу далайн боомт хүртэлх төмөр замын нийт урт 1200 гаруй км. Үүнд Чойбалсан (эсвэл Хөөт)-Бичигтийн замын урт 420 км, БНХАУ-ын хил доторх замын урт 850 км, шугамын хувьд 2 сонголттой. Тус төмөр зам тавигдсанаар одоо байгаа Чойбалсан-Эрээнцавын төмөр замаар дамжин ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замтай холбогдоно. Тус шугам умарш нөөц баялаг ихтэй Өвөр Монголын зүүн, дунд хэсэг, Монгол улсын зүүн гурван аймаг, Оросын Сибирээр дамжин өнгөрч, өмнө зүг шууд Зиньжоу далайн боомтод хүрнэ. Энэ шугам нь Манжуураар дамжин Далянь далайн боомт хүрэх шугамаас бараг 900 км, Улаанбаатараас Эрээн хотыг дамжин Тяньзинь хүрэхээс бараг 800 км дөт тул ач холбогдал маш их. Монголын тал “Нөөц баялгаар төсөл солих” эсвэл ВОТ аргаар хэрэгжүүлж болно⁶.

Хятад-Монгол болон Хятад-Монгол-Оросын харилцан холбох төслийн хамтын ажиллагаа цаашид хөгжихийн хэрээр эрдэс баялаг нийлүүлэлт, логистик худалдаан дахь Монгол улсын дамжин өнгөрөөх зангилаа үүрэг роль улам бүр өсөн дээшилж, Хятад-Орос, Хятад-Европын хамтын ажиллагаа, боомтын эдийн засгийн хөгжилд Монгол нэн дөт, хялбар зам сувгийн байр суурийг эзлэх болно.

4. Бүс нутгийн интеграцчлалын механизм бүрдүүлэх үйл явцыг ахиулах нь

Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны тухай санаачлага давшүүлсэнээс хойш нэгэнт 20 гаруй жил өнгөрсөн боловч ахиц дэвшил байхгүй, үйл явц удааширсаар одоо бүс нутгийн интеграцийн механизмаас гадуур орших цөөн хэдэн бүс нутгийн нэг нь болж үлдэв. Бүс нутгийн интеграцчлалын механизм бий болоход цаг хугацаа, орон зайн хуримтлал хэрэгтэй. Хятад-Монголын ашигт малтмалын хамтын ажиллагаа нь хөрөнгө оруулалт ба худалдааны нэгэн хэлбэр, мөн уул уурхай, эрчим хүчний их хэмжээний барааны урсгал гэсэн үг бөгөөд энэ бүгд нь хоёр талт болон олон талт дэд бүтэц, санхүү,

⁶ Б. Хөгжилт БНХАУ, Монгол улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” сэтгүүл, 2014 он №3. Улаанбаатар хот

чөлөөт худалдааны хэлэлцээр зэрэг төрөл бүрийн интеграцийн үйл явцыг ахиулж, улмаар бүхий л Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны механизмын бүрэлдэн тогтоход асар их үлгэр жишээ болж, түүнд жинтэй хувь нэмэр оруулах нь гарцаагүй.

НОМЗҮЙ

Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад руу зөөвөрлөдөг Монгол “Талын Зам”-аа яаралтай нэвтрүүлэхийг хүсч байна -Herald Tribune, албан ёсны вэб сайт <http://ihl.cankaoxiaoxi.com/2014/1126/> 仅一条铁路口岸输华 蒙古亟待打通“草原之路”_国际先驱导报_《参考消息》官方网站

Си Зиньпин: Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулна. 人民网 Ардын вэб сайт [2014-09-12] [习近平：打造中蒙俄经济走廊](#) . 人民网. [引用日期2014-09-12]

Олон улсын мултимодаль тээврийн болон хуурай замын тээвэр _ Байду номын сан, 国际多式联运及陆路运输_百度文库. <http://wenku.baidu.com/>

1. Монголын төмөр зам, <http://www.mtz.mn>
2. Б. Хөгжилт БНХАУ, Монгол улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” сэтгүүл 2014 он №3, Улаанбаатар.
3. Д. Шүрхүү Монгол-Хятадын эрчим хүч, зам тээвийн салбар дахь хамтын ажиллагаа, “Хятад-Монгол-Орос гурван улсын форум” эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, 2014.06, Бээжин хот
4. Б. Хөгжилт Өвөр Монгол Монгол Улс руу нээлттэй байхын тухай бодолхийлэл, “Умардын эдийн засаг” сэтгүүл, 2014 он, №2, Хөх хот.